



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

**Мал аж ахуй эрхлэхийг хориглох
бүсийн ажлын хэсгийг шинэчлэн
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1589 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн орон сууц, олон нийтийн бүсчлэлд мал аж ахуй эрхлэлтийг цэгцтэй болгох, хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрчимжсэн мал аж ахуйн хөгжүүлэх талаарх бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд дүүргийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд байгаа иргэдийн малыг холбогдох хууль, журмын дагуу нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Мал нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д үүрэг болгосугай.


4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/28 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 02-ны өдрийн
А/62 дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:

Гишүүд:

Нарийн бичгийн
дарга:

Дүүргийн менежер

Дүүргийн Цагдаагийн хэлтэс

Дүүргийн Онцгой байдлын
хэлтэс

Багахангай Гэрэлтүүлэг, ногоон
байгууламж ОНӨААТҮГ

Багахангай теле камер
хяналтын дэд төв ОНӨААТҮГ

Багахангай тохижилт
ОНӨААТҮГ

Дүүргийн мал эмнэлгийн тасаг

Дүүргийн Газар зохион
байгуулалтын албаны дарга

1 дүгээр хорооны Засаг дарга

2 дугаар хорооны Засаг дарга

Хөдөө аж ахуйн тасгийн дарга